

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилго: 1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.

Зорилт: 1.1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 1.1.1 Улирлын томуугийн эсрэг дарлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- 1.1.2 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах.
- 1.1.3 Нэгдсэн эмнэлгийг коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах.
- 1.1.4 Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах.
- 1.1.5 Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх
- 1.1.6 Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах
- 1.1.7 Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт, арга хэмжээнд хамруулах